



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 08 сарын 18 өдөр

Дугаар А/360

Арвайхээр

Бэлтгэл ажлыг хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.л, Засгийн газрын 2020 оны “Хөдөө аж ахуйн салбарын 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 19 дүгээр тогтоолын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах болон бусад цаг үеийн асуудлуудтай холбогдуулан 2020 оны 08 дугаар сарын 25-ны өдрөөр ээлжийн амралтыг тасалбар болгон ажилдаа орсон байхыг сум, багийн Засаг дарга, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

2.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд), сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



И.ДОРЖСҮРЭН

011100795